



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургууль

Хөтөлбөрийн нэр: Хэл шинжлэл /Герман хэл/

Индекс: D023202

Шинжээчийн баг:

Ахлагч:	Д.Энхцэцэг	МУБИС-ийн Багшийн сургуулийн дэд профессор, доктор
Гишүүд:	Ч.Шинэбаяр	Соёл урлагийн их сургуулийн Хөгжлийн хорооны дарга
	Х.Наранчимэг	Хэл шинжлэлийн ухааны доктор, профессор

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

АХБ-Азийн хөгжлийн банк
АШ-Анхан шат
БМИҮЗ-Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БСА-Бакалаврын судалгааны ажил
БНАУ-Бүгд Найрамдах Австри улс
БСХХ-Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо
БХЦСТ-Багшийн хөгжил, цахим сургалтын төв
ГХ-Герман хэл
ГХЗА-Гадаад хэл заах арга зүй
ГЭСА-Германы эрдмийн солилцооны алба
ДБШТ-Дээд боловсролын шинэчлэлийн төсөл
ДЖ-Дадлагын журам
ЕОХСХ-Европын олон хэлний суурь хөтөлбөр
ЕС- Ерөнхий суурь
ЕСТ- Европ судлалын тэнхим
ЕХ- Европын холбоо
ИС- Их сургууль
ИДС- Их, дээд сургууль
КОХА- Номын сангийн автоматжуулсан программ
МИ- Магадлан итгэмжлэл
МТГ- Мэдээллийн технологийн гэээр
МУБИС- Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУИС- Монгол Улсын Их Сургууль
МУСГЗ- Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн
МҮОНТ- Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз
МҮХАҮТ- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
ОТХ- Оюутан төгсөгчийн хэлтэс
ОУ- Олон улс
ОУЭШХ- Олон улсын эрдэм шинжилгээний хурал
ӨҮТ- Өөрийн үнэлгээний тайлан
СБД- Сүхбаатар Дүүрэг
СДХХ- Салбар дундын хөтөлбөрийн холбоо
СиСи- МУИС-ийн сургалтын мэдээллийн систем
СЖ- Сургалтын журам
СНГ- Сургалтын нэгдсэн газар
СТ- Сургалтын төлөвлөгөө
ТББ- Төрийн Бус Байгууллага
ТУЗ- Төлөөлөн Удирдах зөвлөл
ТХХ- Тэнхимийн хөтөлбөрийн хороо
ТҮЦ- Түргэн Үйлчилгээний Цэг /Оюутны автомат машин/
ҮДСБ- Үр дүнд суурилсан боловсрол
ХБНГУ- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЕХ- Хөтөлбөрийн ерөнхий хороо
ХУИС- Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль
ХМИ- Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл
ХУС- Хүмүүнлэгийн ухааны салбар
ХХК- Хариуцлагатай Хувьцаат Компани
ХЧБХ- Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс
ЦЕГ- Цагдаагийн Ерөнхий Газар

ШУ- Шинжлэх ухаан
ШУА- Шинжлэх ухааны академи
ШУС- Шинжлэх Ухааны Сургууль
ШУТИС- Шинжлэх Ухаан Техологийн Их Сургууль
ШХУ- Швейцарын Холбооны Улс
ЭБХ- Элсэлт бүртгэлийн хэлтэс
ЭЕШ- Элсэлтийн ерөнхий шалгалт
ЭШ- Эрдэм шинжилгээ
ЭШБ- Эрдэм шинжилгээний бичиг
ЭШХ- Эрдэм шинжилгээний хурал
ACQUIN-Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллага
CD-Compact disc
CDIO-Conceive Design Implement Operate
CLO- Course Learning Outcomes
DSH- ХБНГУ-ын ИДС-д элсэгч гадаад оюутнаас авдаг герман хэлний шалгалт
HDMI- High Definition Multimedia Interface
LCD- Liquid Crystal Display
MOOC- Massive open online course
NUM- National University of Mongolia
OCW- Open Course Ware
PDF- Portable Document Format
Ph.D- Doctor of Philosophy
PLO- Programm Learning Outcomes
VGI- Volunteered Geographic Information

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургууль School of Arts and Sciences, National University of Mongolia	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Хэл шинжлэл (Герман) German language, Linguistics	
Индекс	D023202	
Шинжээчид	Ахлагч: Д.Энхцэцэг -МУБИС-ийн Багшийн сургуулийн дэд профессор, доктор Гишүүд: Ч.Шинэбаяр- СУИС-ийн Хөгжлийн хорооны дарга Х.Наранчимэг- Хэл шинжлэлийн ухааны доктор, профессор	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2021.12.24	Урьдчилсан үнэлгээний тайланг сургуульд хүргүүлэх
	2021.12.01-02	Сургууль дээр ажиллаж, оролцогч талуудтай уулзаж, нотлох баримтуудтай танилцах
	2021.12.12	Шинжээчийн багийн тайланг БМИҮЗ-д хүргүүлэх
	2021.12.15	Шинжээчийн тайланг БМИҮЗ-ийн мэргэжилтэн сургуульд хүргүүлж, сургуулийн саналыг авах
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Анх 1968 онд МУИС-ийн Хэл бичгийн факультетийн Гадаад хэлний тэнхимийн харъяанд Лайпцигийн ИС-ийн Хердерийн Институтын багш Карл Крюгер, Лайпцигийн ИС-ийг Герман судлаач мэргэжлээр дүүргэсэн Чинагийн Галсан нар физик, математикийн анги, монгол хэлний ангийн зарим нэгэн оюутан, МУИС-ийн багш нарын дугуйланд герман хэлний хичээлийг эхлэн зааснаар тус тэнхимийн шав тавигджээ.

Хожим 1975-1980 оны хооронд Гадаадын жуулчдыг үйлчлэх газрын захиалгаар С.Наваан-Юндэн тэргүүтэй багш нар герман хэлтэй 10 гаруй хөтөч орчуулагчийг бэлтгэн гаргаснаар МУ-д герман хэлтэй үндэсний боловсон хүчин бий болох эхлэл тавигджээ. 1991 оноос герман хэлээр мэргэжсэн гадаад албаны ажилтан, багш-орчуулагч, хэл судлаач, хэл-орон судлаачийг төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургуулиар өдрийн сургалтын хэлбэрээр бэлтгэх үе эхэлсэн. Герман судлалын тэнхим 1993 онд Франц, герман хэлний тэнхимээс тусгаарлан бие даан ажиллах болжээ. 1995-2021 онд герман хэлний багш, орчуулагч, гадаад албаны ажилтан/герман/, герман судлал, герман хэл шинжлэллийн бакалаврын нийт 463 мэргэжилтэн төгссөн байна.

Тайлангийн хугацаанд Хэл шинжлэл /герман/ хөтөлбөрийн хэрэгжүүлэгч нийт 6 үндсэн багш, нэг цагийн багш ажиллаж байна.

	Албан тушаалын зэрэглэл	Эрдмийн зэрэг, цол	Ажилласан жил /МУИС/
1. Ж.Ариун	дэд профессор	Ph. доктор	30 жил /МУИС 17 жил/
2. Г.Гэрэлмаа	ахлах багш	магистр	18 жил /МУИС 13 жил/
3. М.Одонтуяа	ахлах багш	магистр	20 жил /МУИС 13 жил/
4. Б.Энхболд	багш	магистр	13 жил /МУИС 13 жил/
5. Ч.Сэлэнгэмөрөн	ахлах багш	магистр	19 жил /МУИС 18 жил/
6. Г.Эрдэнэнаран	ахлах багш	Ph. доктор	17 жил /МУИС 12 жил/
7. Йелем Инанчи /ГЭСА/	цагийн багш	магистр	МУИС 3 жил

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмарк, судалгааны танилцуулга /PDCA, STEEP гэх мэт/ ӨҮТ1-3
- Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, ӨҮТ4-9

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУ-ын боловсролын тухай хууль, МУ-ын дээд боловсролын тухай хууль, төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүд, МУИС-ийн захирлын тушаал, шийдвэр гэх мэт хууль эрх зүйн баримт бичгүүдийг нягт судласан байна.
- Дэлхийн шилдэг их сургуулиудаас Станфордын ИС, Мюнхены Людвиг Максимиллианы ИС, Westfälische Wilhelms-Universität Münster их дээд сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулан судалсан байна.
- Мөн хятад, япон, солонгос орны “герман хэл” судлах хөтөлбөрийн багц цагуудыг харьцуулан судалжээ.
- Хэл шинжлэл хөтөлбөрийн STEEP шинжилгээ хийгдсэн байна.

Анхаарах асуудал:

- Яг “Герман хэл шинжлэл” хөтөлбөрийн сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн нарийвчилсан дүн шинжилгээ дутмаг байгаад анхаарч ажиллах

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар ӨҮТ12
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг ӨҮТ10

- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн талаар баримт материал ӨҮТ12-13

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлж өгсөн.
- Олон хэлний суурь хөтөлбөрийн ерөнхий чадамж, МУИС-ийн бакалаврын хөтөлбөрүүдийн эрхэм зорилго, төгсөгчийн загвар, оролцогч ба сонирхогч талуудын сонирхол гэх мэт олон хүчин зүйлийг харгалзан Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна.
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлэхдээ хэвлэмэл ба цахим хэлбэрийг ашиглажээ.

Анхаарах асуудал:

- “Герман хэл шинжлэл” Хөтөлбөрийн өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн эх материалууд хэдийд ямар хугацаатай мэдээлэгдэж байсан эсэх нь тодорхой бус байна.

Зөвлөмж:

- “Герман хэл шинжлэл” хөтөлбөрийн өөрчлөлтийн талаар олон нийт болон ажил олгогчдод тогтмол мэдээлдэг байх

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Батлагдсан хөтөлбөр
- Хурлын тэмдэглэл
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/
- Батлагдсан хичээлийн хөтөлбөр
- Өөрийн үнэлгээний тайлангийн хуудас 13-17

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг баталгаажуулж, сайжруулдаг үйл явц онцлог сайн байна
- “Герман хэл шинжлэл” хөтөлбөрийн PLO-г тодорхойлсон
- Бүх хичээлийн хөтөлбөрүүд дээр CLO-г тодорхойлсон
- Шалгуурт SWOT/TOWS шинжилгээ хийсэн

Анхаарах асуудал:

- “Герман хэл шинжлэл” хөтөлбөрийн PLO1- PLO35 бөгөөд нэг PLO-той дунджаар 15 CLO-тэй матриц үүсгэж байна. Гэтэл PLO15-тай 61 CLO, PLO31, PLO32, PLO33-тай 2,2,1 CLO матриц үүсгэж байгааг анхаарах
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөны хувьд Ерөнхий суурь 36кр, Мэргэжлийн суурь 9 кр, Мэргэшүүлэх 75кр байгаа нь A/174-р тушаалд заагдсан Ерөнхий суурь 30кр-ээс илүүгүй, Мэргэжлийн суурь 25 кр-ээс илүүгүй, Мэргэшүүлэх 75кр-ээс доошгүй гэж заасантай зөрчилд хүрч байгааг анхаарах. Учир нь ерөнхий суурь хичээл нь мэргэжлийн суурь хичээлээс 4 дахин их, мэргэжлийн суурийн заавал судлах хичээл нь *-оор тэмдэглэгдсэн бөгөөд 3кр байгаа нь хангалтгүй байна.

Зөвлөмж:

- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний Ерөнхий суурь, Мэргэжлийн суурь, Мэргэшүүлэх хичээлүүдийн кредитийн харьцааг дахин хэлэлцэх
- Тухайн хөтөлбөрийн (PLO) болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн (CLO) матрицыг улам боловсронгуй болгох

Шаардлага:

- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний Ерөнхий суурь, Мэргэжлийн суурь, Мэргэшүүлэх хичээлүүдийн кредитийн харьцааг A/147 тоот тушаалыг баримтлан өөрчлөх
- Тухайн хөтөлбөрийн (PLO) болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн (CLO) матрицыг улам боловсронгуй болгох

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц; “Герман хэл шинжлэл” хөтөлбөрийн хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график буюу “хөтөлбөрийн мод”; уг хөтөлбөрийн сургалтын дэлгэрэнгүй төлөвлөгөө; дадлагын талаар хамтран ажиллах журам, гэрээ, удирдамж, дадлагын хамтрагч байгууллагуудын жагсаалт;
- Хэл шинжлэл хөтөлбөрөөр оюутан, суралцагчдаас СиСи системээр авсан санал асуулгын дүн мэдээ (2015-2020 он); оюутны цагийн ачаалал тооцсон судалгаа зэрэг баримт, материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Герман хэл шинжлэл” хөтөлбөрийг Европын олон хэлний суурь хөтөлбөр болох баримт бичигт тулгуурлан Америк, Европын ижил төстэй хөтөлбөрүүдийг судлан харьцуулж, боловсруулсан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн Мэргэжлийн суурь хичээл / Б. /-9 багц цаг хэт их, харин мэргэжлийн сонгон судлах хичээл / B2. / - 6 багц цаг хэт бага байгаа тул энэхүү харьцааг цаашид анхаарах шаардлагатай.
- Ерөнхий ба мэргэжлийн орчуулгын онол, герман хэлний хэлмэрчлэхүй практик сургалт хоорондын харилцан уялдаа, залгамж холбоог улам сайжруулах.
- Оюутны бие даалт болон мэргэшүүлэх, үйлдвэрийн дадлагын цагийг ахиулах, илүү үр өгөөжтэй болгох тал дээр анхаарах.
- Хичээл, багшаа сонгох боломжтой ч техникийн саатал, багшийн ачаалал, сонголт хийсэн оюутны тоо бага гэх мэт шалтгааны улмаас чөлөөт сонголтыг зохих ёсоор нь бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүй байгааг анхаарах.
- Нотлох баримттай танилцах явцад “Магадлан итгэмжлэлийн хүсэлтийн хавсралт” дотор хоёр хичээлийн хөтөлбөрийн нэршлийг андууран англи хэлээр буруу оруулсан байгааг тогтоов: 1“Үгийн сан судлал” хичээлийн хөтөлбөрийг Morphology бус “Lexicology” 2.“Герман орон судлал” хөтөлбөрийг German studies биш “German regional studies” болгож тус тус өөрчлөх шаардлагатайг анхааруулсан.

Зөвлөмж:

- “Хэл шинжлэл” хөтөлбөрт орчуулгын онол, семинарын хичээлүүд / B2. Сонгон судлах хичээл/ чухал байр суурь эзэлдэг тул ерөнхий орчуулгын онол /A./ төдийгүй тухайн гадаад хэлний орчуулгын онол болон мэргэжлийн орчуулга гэх мэт хичээлийг шинээр оруулах шаардлагатай гэж үзэж байна.
- Бакалаврын судалгааны ажилд 3 багц цаг ногдож байгаа ч сурлагын голч дүн нь 2.8 - аас дээш оюутан л зөвхөн бичих юм байна. Бакалаврын судалгааны ажил бичих, төгсөлтийн мэргэжлийн шалгалт өгөх зэрэг нь төгсөгчдийн чадамжийг дүгнэх үндсэн шалгуур болдог тул эдгээрийг хөтөлбөрт зайлшгүй оруулахыг зөвлөмж болгож байна.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- “Хичээлийн хөтөлбөр боловсруулах заавар”, “Гадаад хэлний сургалтын агуулгын зөвлөмж”, ЕОХСХ (монгол хэлээр)
- Хөтөлбөрийн хичээлүүдийн арга зүйн анализ (идэвхтэй болон идэвхгүй сургалтын арга зүйн харьцаа, идэвхтэй/ идэвхгүй сургалтын аргыг хэрэглэдэг/хэрэглэдэггүй байдлын харьцуулалт);
- МХХДТехнологи болон төрөл бүрийн программ ашигладаг хичээлийн тоо
- Уг хөтөлбөрийн 20 орчим хичээлийн талаар явуулсан санал асуулгын үр дүн / тухайн хичээлд хэрэглэдэг ном, сурах бичиг, гарын авлага; тухайн хичээлийн агуулга, зохих түвшний мэдлэг, чадвар олгож байгаа эсэх, тавигдсан зорилгод нийцэж байгаа эсэх талаар/
- Багш, сургалтын орчин, мэргэжлийн заавал ба сонгон судлах хичээлийн талаар оюутнуудын дунд явуулсан сэтгэл ханамжийн судалгаа, үр дүн зэрэг нотлох баримт, материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтыг албан ёсны лицензтэй Майкрософт Тиймз платформ дээр шууд буюу синхрон зохион байгуулж байна.
- Сургалтад ХБНГУ-ын багш, мэргэжилтнүүдийн боловсруулсан сурах бичгийг хэрэглэхээс гадна монгол оюутан, суралцагчийн онцлогийг харгалзсан, хөтөлбөр хэрэгжүүлэгч эрдэмтэн, багш нарын өөрийн зохиосон дүрмийн сурах бичиг, гарын авлагыг хэрэглэж байна.
- Байгуулагдаад удаагүй байгаа “Хэлний туршилтын судалгааны төв” нь аливаа хэлний суурийн суурь болох авиазүй, авиалбар зүйн хичээлийн сургалтад нэн хэрэгцээтэй юм.
- “Жайка” төслөөр байгуулагдсан “Хэлмэрчлэхүйн лабораторид” төрөл бүрийн синхрон орчуулга хийх боломжтой юм байна.
- Оюутан суралцагсад Герман хэлний хэлмэрчлэхүй, Албан бичгийн орчуулга, Уран зохиолын орчуулгын хичээлээр бие даалтын бүтээлч олон ажил гүйцэтгэхээс гадна багш нартайгаа хамтран 2019 оны хичээлийн жилээс эхлэн дунд, дээд шатны унших, бичих хичээлийн хүрээнд Герман болон бусад олон улсын оюутнуудтай хамтран “Хулганын аялал” цахим төсөлд багаараа оролцож байгаа нь нэн сайшаалтай.
- Сургалтын арга зүй нь уг хөтөлбөрийн зорилгод бүрэн нийцсэн байна; мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг байнга шинэчлэн сайжруулж, уламжлалт ба орчин үеийн шинэлэг аргыг хослуулан ашигладаг байна.

Анхаарах асуудал:

- МУИС-ийн МТ-ийн СиСи систем нь цахим сургалт болон сургалтын бүхий л үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэхээр ирсэн боловч хичээлийн чөлөөт сонголтыг хийх, түүнчлэн цахим сургалтыг явуулахад техникийн удаашрал, гацаа үүсдэг хэмээн оюутан, төгсөгч, багш нартай хийсэн уулзалт, ярианаас тодорхой байгаа тул үүнд онцгойлон анхаарах нь зүйтэй.

Зөвлөмж:

- Уг хөтөлбөрийг боловсруулсан баг өөрийн үнэлгээний тайландаа: “ҮДСБ-ын үзэл баримтлал, сургалтын арга зүй, Европын олон хэлний суурь хөтөлбөрийн олон хэл, соёлын хандлага, түүнчлэн ЮНЕСКО- ийн XXI зууны боловсролтой иргэний тулгуур зарчим зэргийг нэг дор нөхцөлдүүлэн уг хөтөлбөрөө сайжруулах шаардлагатай” гэж бичсэнийг бүрэн дэмжиж зөвлөмж болгон хүргүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус хөтөлбөрийн хэлний чадамж, хэлэхүйн дадлын хичээлүүдийн түвшин тус бүрд хэрэглэдэг сурах бичгүүд,
- Түвшин тогтоох шалгалт болон олон улсын хэлний стандарт шалгалтын тестийн сан, сорилын санд хийсэн дүн шинжилгээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гёте институтийн Zertifikat Deutsch, TestDaF институтийн TestDaF шалгалт, Австри улсын герман хэлний ÖSD, EOXCX – ийн дагуу боловсруулсан олон улсын хэлний telc зэрэг стандарт шалгалтын тестийг хэрэглэж, тестийн сан бүрдүүлсэн.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багаас авч буй тестийн чанарт дүн шинжилгээ хийх, шалгалт, тестийн онолоор нэг багшийг мэргэшүүлэхэд анхаарах.

Зөвлөмж:

- Үг хөтөлбөр нь ойрын ирээдүйд дангаараа оршин тогтнож, үйлчлэх чадамжтай хөтөлбөр байна. Алс ирээдүйд уг хөтөлбөрийг бусад мэргэжилтэй хослуулбал зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах, хөрвөх чадвартай боловсон хүчин бэлтгэхэд илүү үр өгөөжтэй болох болно гэсэн зөвлөмж өгч байна / Жишээ нь: Хэл шинжээч – хуулийн салбарын орчуулагч; Эдийн засгийн орчуулагч – хэл шинжээч гэх мэт хос мэргэжил/.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа
- Өөрийн үнэлгээний тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын орчин болон түүний хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааг 2016 оноос хойшхи 4 хичээлийн жилийн судалгааг 5 хичээлийн жишээгээр авч харьцуулсан байна
- Шаардлагатай тоног төхөөрөмж, лаборатори, мэдээллийн технологийн хэрэгслээр хангагдсан

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал
- Өөрийн үнэлгээний тайлан хуудас 43-46

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн сургалт, судалгаандаа ашигладаг лицензтэй ба лицензгүй программууд болон багш нарын цахим хичээл боловсруулах арга зүйд суралцсан байдал, Сургалтын

хэрэглэгдэхүүн, нөөцийн хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг тодорхой тусгасан.

- Хэл заслын нарийн тоног төхөөрөмж бүхий өрөө
- Синхром орчуулгын дадлага хийх өрөө

Анхаарах асуудал:

- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материалуудаа баяжуулахад анхаарах

Зөвлөмж:

- Оюутны сэтгэгдэлд дүн шинжилгээ хийж, онлайн хичээлийн чанарт анхаарах

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа
- Өөрийн үнэлгээний тайлан 46-49
- МУИС-ийн номын сан, номын сангийн үйл ажиллагаа, орчин
- 2015-2020 хугацаан дахь ном, хэвлэлийн бүтээгдэхүүний судалгаа
- 2017-2020 оны МУИС-ийн гадаадын онлайн сан ашиглалтын судалгаа
- Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашигладаг ном, эх сурвалжийн бүртгэл
- Шалгуур3 SWOT/TOWS шинжилгээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Өөрийн үнэлгээний тайлан 50-52х, Хавсралт 4.1.4
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ ӨҮТ 52-54х
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан ӨҮТ 55х, Хавсралт 4.1.6
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ ӨҮТ 54-55х
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ ӨҮТ 55-57х

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн хэмжээнд Хөтөлбөрийн хороодын үйл ажиллагаа тогтворжсон. Эрх зүйн орчин бүрдсэн, холбогдох дүрэм, журмуудыг мөрдөн ажиллаж байна. ЕСТ болон ТХХ хөтөлбөрийн шинэчлэл, сайжруулалтыг тогтмол хийж ирсэн байна.
- МУИС-д СиСи системийг нэвтрүүлснээр сургалтын бүх үйл ажиллагааг шуурхай явуулах, ил тод байдлыг хангах, оролцогч талууд хяналт тавих нөхцөл бүрдсэн байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчдын тоо, цахим сургалтын хэрэглээ нэмэгдэж байгаатай холбоотой СиСи системийн хэрэглээнд доголдол гардаг байна. Ялангуяа хичээл сонголтын үед уг систем гацдагаас суралцагчдад хохиролтой нөхцөл үүсдэг байна.

Зөвлөмж:

- СиСи системийг байнга хөгжүүлэх

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан ӨҮТ 57, 59х, Хавсралт 4.2.1, 4.2.2
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам ӨҮТ 58-59х
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/ ӨҮТ 60-61х
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл ӨҮТ 61х

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаад хамтын ажиллагаа сайн хөгжсөн. Монгол дахь ОУ-ын байгууллагууд, ТББ, бизнесийн байгууллагуудтай тогтвортой хамтран ажилладаг.
- Оюутнуудыг гадаадын тэтгэлэгт хамруулах, герман хэлтэй улсад суралцах, ажиллах боломж олгохын тулд санаачилгатай, үр дүнтэй ажилладаг.
- Герман хэлний сургалттай ЕБС болон бусад их, дээд сургуулийн суралцагчид, багш нарт зориулсан болон олон нийтэд герман хэл, соёлыг сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Багш нар олон улсын хурал зөвлөгөөнд оролцож, сургалтад хамрагдагч герман хэлтэй улсын их, дээд сургуульд багшлах дадлага хийх боломж хараахан бүрдээгүй байна.
- Оюутнууд солилцооны хөтөлбөр хэрэгжүүлдэггүй учраас оюутнууд өөрийн суралцаж байгаа мэргэжлээрээ герман хэлтэй улсын их, дээд суралцах боломж байхгүй байна.

Зөвлөмж:

- Герман хэлний орнуудын их, дээд сургуулиудтай тогтоосон сайн хамтын ажиллагаагаа өргөжүүлэн багш, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх
- Төгсөгчид болон энэ мэргэжлийн хүмүүст шаардлагатай байгаа мэргэжүүлэх сургалтын судалгаа хийж, сертификаттай сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх

Шаардлага:

- Герман хэлтэй орнуудын их, дээд сургуулиудтай хамтарсан багш, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан Хавсралт 4.3.1, 4.3.2, 4.3.3
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо ӨҮТ 63х
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа ӨҮТ 62-63х
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт ӨҮТ 63-64х
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан ӨҮТ 64-65х

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж санхүүгийн хувьд тодорхой хэмжээний эрх мэдэлтэй.

- ГЭСА болон хамтын ажиллагаатай гадаадын бусад байгууллагын мөнгөн бус хандив, дэмжлэгээр сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэх, багш нар мэргэжил дээшлүүлэх боломж бүрддэг.

Анхаарах асуудал:

- Одоогийн байдлаар оюутны сургалтын төлбөрөөс өөр санхүүжилтийн бодит эх үүсвэр байхгүй байна.

Зөвлөмж:

- Санхүүжилтийн олон эх үүсвэртэй болох талаар санаачилгатай ажиллах, тухайлбал насан туршийн боловсролыг дэмжих бодлогын хүрээнд ажлын байрны шаардлагад нийцсэн төлбөртэй мэргэшүүлэх сургалтууд болон хамтын ажиллагаатай гадаадын их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан зуны сургалт зохион байгуулах

Шаардлага:

- Сургалтын төлбөрөөр гадна санхүүжилтийн нэмэлт эх үүсвэр бий болгох боломжийг судалж, ажиллах

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал ӨҮТ 65-66х
- Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт ӨҮТ 66-67х

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн хэмжээнд хөтөлбөрийн маркетингийн үйл ажиллагаа тогтмолжсон, тодорхой төлөвлөгөөтэй хэрэгждэг бөгөөд энэ үйл ажиллагаанд ЕХТ, тус хөтөлбөрийн нэгж байнга идэвхтэй оролцдог байна.

Зөвлөмж:

- Элсэгчдийн тоог нэмэгдүүлэхийн тулд зорилтот бүлэгт хандсан идэвхжүүлэлтийн тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх
- Хөтөлбөрийн эрэлтийг нэмэгдүүлэхийн тулд тус хөтөлбөрийг хавсарга болон хос мэргэжлийн хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлэх боломжийг судлах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт ӨҮТ 67х
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа ӨҮТ 67-68х, Хавсралт 4.5.1

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг МУИС-ийн вэб хуудас, мэдээллийн бусад сувгаар дамжуулан олон нийтэд хүргэдэг. Элсэгчдэд зориулсан сурталчилгааны хэвлэмэл материалуудыг бэлтгэдэг. Мэдээллийн үнэн зөв, ил тод байдлыг хангаж ажилладаг байна.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн бодлого, дүрэм журам ӨҮТ 70-71х
- Элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо ӨҮТ 72х
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага ӨҮТ 72х
- Гадаад оюутны элсэлтийн тоо ӨҮТ 72х

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн элсэлтийн бодлого, дүрэм журам цэгцэрсэн.
- Элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалт тогтмолжсон байна.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан ӨҮТ 73х
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал ӨҮТ 73-74х
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ ӨҮТ 74-76х
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тайлан мэдээ ӨҮТ 76-77х

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-ийн хэмжээнд Оюутан, төгсөгчийн хэлтэс хариуцан оюутны үйлчилгээг үзүүлдэг.
- Багш нарт хичээлийн жилийн эхэнд заах хичээл бүрт суралцагчдад тухайн хичээлийг суралцах, судлах талаар зөвлөгөө өгөх тодорхой цагийг төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлийг жилийн эцэст тооцдог байна.

Зөвлөмж:

- Оюутны мэргэжлийн дадлагыг илүү үр бүтээлтэй болгохын тулд дадлагад гарахаас нь өмнө зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байх

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны клубын зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ ӨҮТ 77-78х
- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл ӨҮТ 78-79х
- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон оюутны тоо, үр дүнгийн мэдээлэл ӨҮТ 80х
- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо ӨҮТ 79х

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн гадаад, дотоод хамтын ажиллагаа нь суралцагчид, төгсөгчдийг цагийн ажил, үндсэн ажилд зуучлах болон оюутнуудад Герман, Швейцарт суралцах тэтгэлэгт хамрагдах боломж олгодог.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн олон нийтийн оролцоо, сайн дурын ажлыг хэрхэн урамшуулдаг нь тодорхойгүй байна.

Зөвлөмж:

- Суралцагчийн олон нийтийн оролцоо, сайн дурын ажлын урамшууллыг тодорхой болгох

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа ӨҮТ 80-82х, Хавсралт 5.4.1
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам ӨҮТ 82-83х, Хавсралт 5.4.2

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС багц цагийг дүйцүүлэн тооцох нэгдсэн систем мөрддөг. Тухайлбал, Кембриджийн хөтөлбөрийн хичээл.
- Дотоодын их, дээд сургуулийн дүн болон гадаадын түгээмэл хэрэглэгдэг үнэлгээг дүйцүүлэх нэгдсэн журамтай.

Анхаарах асуудал:

- Тэтгэлийн хөтөлбөрт хамрагдан гадаадад жилийн хугацаагаар суралцсан оюутнуудын зарим нэг хичээлийг дүйцүүлдэггүй нь тухайн оюутанд хохиролтой байдаг гэсэн мэдээлэл байна.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичгийн загвар ӨҮТ 83х, Хавсралт 5.5.1
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал ӨҮТ 83х

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа, багш, суралцагчдын тооны харьцааны сүүлийн 5 жилээр хийсэн судалгаа,

багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа, багш нарт олгосон урамшууллын журам, судалгаа зэрэг нотлох баримттай танилцав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч баг нь мэргэжлийн олон жилийн туршлагатай, сургалтын арга зүйн өндөр чадвартай багш нараас бүрдсэн байна.

Анхаарах асуудал:

- Герман хэл шинжлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 6 багшийн хоёр нь эрдмийн цол зэрэгтэй /33.3% нь Ph.D/ , бусад дөрвөн багш магистр байна. Иймээс докторын зэрэгтэй багш нарын тоог ахиулахад нэн тэргүүнд анхаарах шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч магистр багш нар цагийн өндөр ачаалалтай ажилладаг юм байна. Иймээс 3-9 сарын хугацаатай “эрдмийн чөлөө” олгох байдлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх боломжийг нь нээж өгөх.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хувийн төлөвлөгөө болон тайлан, багш нарын гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлсэн судалгаа зэргийг харуулсан багш тус бүрийн дэлгэрэнгүй хавтастай танилцав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн “Багшийн хөгжил, цахим сургалтын төв” нь багш нарын сургалт, судалгааны ажлыг хөхиүлэн дэмждэг юм байна.
- ХБНГУ-ын ГЭСА, Гёте институт, Рур болон Бохумын Их Сургууль зэрэг байгууллага, их сургуультай шууд харилцаа холбоотой тул багш нар богино ба урт хугацааны тэтгэлгээр гадаадад эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, мэргэжил дээшлүүлэх боломжтой.

Анхаарах асуудал:

- “Багшийн хөгжил, цахим сургалтын төвөөс” багш нарын дунд академик хэрэгцээний тандалт судалгаа явуулсан байна. Уг судалгааны үр дүнд: “...багш нар судалгааны ур чадвараа дээшлүүлэх, англи хэлээр судалгаа хийх, хэвлэн нийтлүүлэх ур чадвараа ахиулах хэрэгцээ шаардлагатай байна.” / ӨҮТ, хуудас 90/ гэсэн санааг анхааралдаа авч, мөрөөр ажиллах нь чухал гэж үзэж байна.

Зөвлөмж:

- МУИС-ийн удирдлагын зүгээс багш нарын хөгжлийн цогц бодлогыг тасралтгүй хэрэгжүүлж, олон төрөл, арга хэлбэр, чиглэлээр багш нараа байнга дэмжиж, хамтран ажиллаж, академик сургалт, эрдэм шинжилгээ судалгаа явуулах объектив бүхий л боломж, нөхцөлийг бүрдүүлж ирсэн байна. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багийн гишүүд сургалт, судалгаа, хэвлэн нийтлүүлэх ур чадвараа улам нэмэгдүүлж, эрдмийн зэргээ ахиулахад илүү идэвх санаачилгатай ажиллах.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Тэнхимийн багш нарын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, нийтлэгдсэн бүтээлийн жагсаалт, судалгааны суурь зардал болон багш дэмжих зардлын төсөв, тайлан, зарцуулалт гэх мэт нотлох баримттай дэлгэрэнгүй танилцав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017 оноос хойш жил бүр зохион байгуулдаг “Европ судлал: Олон улсын харилцаа: хэл шинжлэл, орчуулга судлал, гадаад хэлний боловсрол” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг дотоод болон гадаадын олон орны нэр хүнд бүхий байгууллага, түүнчлэн МУБИС, ШУТИС, ХААИС, ҮБХИС болон бусад их, дээд сургууль хамтран зохион байгуулж ирсэн уламжлалтай юм. Олон улсын энэхүү бага хуралд АНУ, ОХУ, Герман, Франц зэрэг олон орны эрдэмтэн, судлаачид оролцон туршлага солилцож, мэргэжлийн ур чадвараа сорих талбар хэдийнээ болсон байна. Уг хурлаар хэлэлцүүлсэн илтгэлүүдийг “Европ судлал” сэтгүүлд хэвлүүлэн, олны хүртээл болгож байна.
- 2015-2020 оны байдлаар тус хөтөлбөрийн багш нар дотоод болон олон улсын эрдэм шинжилгээний хуралд нийт 20 илтгэл хэлэлцүүлсэн нь бусад эрдэм шинжилгээний ажлын үзүүлэлттэй харьцуулахад хамгийн өндөр байна.

- Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар тайлант хугацаанд дотоодын санхүүжилттэй 4 төсөлд удирдагч болон оролцогчоор оролцсон байна. 2015-2016 оны хичээлийн жилд: “Дэлхийд түгсэн Монголын нууц товчоо” - хамтын бүтээлийн төсөл, 2018-2020 оны хичээлийн жилд: “Дэлхийн соёл иргэншил” - ерөнхий суурийн сурах бичиг зохиох гадаад хэлний багш нарын хамтын бүтээл төсөл.
- Тайлангийн хугацаанд “Хэл шинжлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багийн багш нар 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, дотоодын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна. Хэвлэн нийтлүүлсэн өгүүллийн судалгааны чиглэлийг харьцуулахад: “Боловсрол судлал” чиглэлээр - 45.8%, “Хэл шинжлэл” - 25%, орчуулга судлал – 20.8%, орон судлал – 8.3% тус тус эзэлж байна.

Анхаарах асуудал:

- Тайлангийн хугацаанд хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар гадаадын мэргэжлийн сэтгүүлд 2 өгүүлэл хэвлэн нийтлүүлсэн нь чамлалттай байна.
- Хэл, соёл, орон судлал, орчуулга судлал гэх олон чиглэлээр гадаадын санхүүжилттэй төсөл оруулж ирэх, хамтарсан төсөлд оролцоход илүү анхаарах.

Зөвлөмж:

- Цаашид “Jahrbuch für Internationale Germanistik“, „Deutsch als Fremd- und Zweitsprache“ зэрэг гадаадын мэргэжлийн нэр бүхий нийгэмлэгүүдийн ном, сэтгүүл болон Web of Science , Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлэн нийтлүүлэхийг зорьж ажиллах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн өөрийн үнэлгээний тайлан, хэрэгжилтийн тайлан, мэдээ, хөндлөнгийн үнэлгээний тайлан, дүн, багш нарын хавтас зэрэг нотлох материалтай дэлгэрэнгүй танилцав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын ажлын үнэлгээг: 1. Сургалт, заах арга зүй 2. Эрдэм шинжилгээ, судалгаа 3. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ гэсэн гурван чиглэлээр, оюутны сэтгэл ханамжийн судалгаа, комиссын үнэлгээ, удирдлагын үнэлгээ зэрэг гурван шатлалтай явуулдаг нь тал бүрийн үр өгөөжтэй юм.

Анхаарах асуудал:

- Тайлангийн хугацаанд хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын сургалтын үйл ажиллагааны А, Б, В цагийн гүйцэтгэл нормоос дунджаар 3.08 – 5 багц цагаар илүү байгаа нь сургалтын чанар, мөн багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд төвлөрч ажиллах зэрэгт сөргөөр нөлөөлөх талтай тул үүнд анхаарах шаардлагатай.

Зөвлөмж:

- Аливаа орны их, дээд сургуулийн багшийг үнэлгээний чухал үзүүлэлт болох: 1. эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож буй байдал, 2. гадаад, дотоодын нэр хүндтэй мэргэжлийн сэтгүүлд хэвлэн нийтлүүлсэн байдал, 3. олон улсын төсөлд оролцож буй байдал зэргээр үнэлдэг тул цаашид үүнийг анхааралдаа авч ажиллах зөвлөмжийг хөтөлбөр хэрэгжүүлэгч бүх багш нарт хүргүүлж байна.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем.
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ ӨҮТ 100-106
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хариуцсан ажилтан, нэгж, Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын удирдлагын зохион байгуулалт
- Сургалтын үйл ажиллагааг шинжлэн дүгнэх сургалтын чанарын тогтолцооны бүдүүвч

- Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын эрх зүйн орчин
- Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийх үнэлгээний хэвшсэн тогтолцоо

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- “Герман хэл шинжлэл” хөтөлбөрөөр төгсөгчдийн ажиллах хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт хэрэгцээ илрүүлэх судалгаа хийх

Зөвлөмж:

- Яг хэл шинжлэлээрээ мэргэшин ажиллаж байгаа төгсөгчдийн нарийвчилсан судалгаа хийх

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, үр дүнг хөтөлбөрийн шинэчлэлт тусгадаг байдал
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн одоогийн төлөвийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, үр дүнг хөтөлбөрийн шинэчлэлт тусгадаг байдал
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг зохион байгуулдаг аргачлал ба судалгааны үр дүнг хөтөлбөрийг хөгжилд ашигладаг байдал
- Тухайн хөтөлбөрөөр 2016-2020 оны төгсөгчдийн голч онооны дунджийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ хийх
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа тусгаж ажиллах

Зөвлөмж:

- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хөтөлбөрт тусгах

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа, /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ
- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь **ӨҮТ 111-120**

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн ОУ-д хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын их дээд сургуульд элсэн суралцах хэлний шалгалтад хэрхэн тэнцэж байсныг тодорхой тусгасан
- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн судалгаа
- Шалгуур7 SWOT/TOWS шинжилгээ хийсэн

Зөвлөмж:

- Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, хийсэн ажлууд, үр дүнд задлан шинжилгээ хийх

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2	1	0	-Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний Ерөнхий суурь, Мэргэжлийн суурь, Мэргэшүүлэх хичээлүүдийн кредитийн харьцааг дахин хэлэлцэх -Тухайн хөтөлбөрийн (PLO) болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн (CLO) матрицыг улам боловсронгуй болгох
2	Сургалтын үйл ажиллагаа	3	0	0	
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	3	0	0	
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	3	2	0	-Герман хэлний орнуудын их, дээд сургуулиудтай тогтоосон сайн хамтын ажиллагаатай боловч багш, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлдэггүй байна. -Оюутны сургалтын төлбөрөөс өөр санхүүжилтийн бодит эх үүсвэр байхгүй байна.
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5	0	0	
6	Багшлах бүрэлдэхүүн	4	0	0	
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	3	0	0	
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн “Хэл шинжлэл (герман)” хөтөлбөрийг БМИУЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургууль
Хөтөлбөрийн нэр	Хэл шинжлэл (герман)
Хөтөлбөрийн индекс	D023202
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	-Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний Ерөнхий суурь, Мэргэжлийн суурь, Мэргэшүүлэх хичээлүүдийн кредитийн харьцааг дахин хэлэлцэх -Тухайн хөтөлбөрийн (PLO) болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн (CLO) матрицыг улам боловсронгуй болгох
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	-“Хэл шинжлэл” хөтөлбөрт орчуулгын онол, семинарын хичээлүүд / B2. Сонгон судлах хичээл/ чухал байр суурь эзэлдэг тул ерөнхий орчуулгын онол /A./ төдийгүй тухайн гадаад хэлний орчуулгын онол болон мэргэжлийн орчуулга гэх мэт хичээлийг шинээр оруулах шаардлагатай гэж үзэж байна. -Бакалаврын судалгааны ажилд 3 багц цаг ногдож байгаа ч сурлагын голч дүн нь 2.8 -аас дээш оюутан л зөвхөн бичих юм байна. Бакалаврын судалгааны ажил бичих, төгсөлтийн мэргэжлийн шалгалт өгөх зэрэг нь төгсөгчдийн чадамжийг дүгнэх үндсэн шалгуур болдог тул эдгээрийг хөтөлбөрт зайлшгүй оруулахыг зөвлөмж болгож байна.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	-Герман хэлний орнуудын их, дээд сургуулиудтай тогтоосон сайн хамтын ажиллагаагаа өргөжүүлэн багш, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх -Төгсөгчид болон энэ мэргэжлийн хүмүүст шаардлагатай байгаа мэргэжүүлэх сургалтын судалгаа хийж, сертификаттай сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж санхүүжилтийн нэмэлт эх үүсвэртэй болох
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	-Оюутны мэргэжлийн дадлагыг илүү үр бүтээлтэй болгохын тулд дадлагад гарахаас нь өмнө зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байх
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	-Хөтөлбөр хэрэгжүүлэгч багийн гишүүд сургалт, судалгаа, хэвлэн нийтлүүлэх ур чадвараа улам нэмэгдүүлж, эрдмийн зэргээ ахиулахад илүү идэвх санаачилгатай ажиллах.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	-Хэл шинжлэлээр мэргэшин ажиллаж байгаа төгсөгчдийн нарийвчилсан судалгаа хийх
ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/	
	➤

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг /Д.Энхцэцэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Ч.Шинэбаяр/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Х.Наранчимэг/

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэр	Албан тушаал	Ажилласан жил	Эрдмийн зэрэг, цол
1	Ж.Ариун	Дэд профессор	30 жил /МУИС 17 жил/	Доктор (Ph.D)
2	Г.Эрдэнэнаран	Ахлах багш.	17 жил /МУИС 12 жил/	Доктор (Ph.D)
3	Ч.Сэлэнгэмөрөн	Ахлах багш	19 жил /МУИС 18 жил/	Магистр
4	Г.Гэрэлмаа	Ахлах багш	19 жил /МУИС 13 жил/	Магистр
5	М.Одонтуяа	Багш	20 жил /МУИС 13 жил/	Магистр
6	Б.Энхболд	Багш	13 жил /МУИС 13 жил/	Магистр

№	ОВОГ НЭР	ЗААДАГ ХИЧЭЭЛ
1	Ж.Ариун	Герман хэлний үг зүй GERM 321, Герман хэлний өгүүлбэр зүй GERM 322, Герман хэлний үгийн сан судлал GERM 323, Герман хэлний хэл зүй /дээд шат/ GERM 309, Үйлдвэрлэлийн дадлага INT 400, Бакалаврын судалгааны ажил THES 400
2	Г.Эрдэнэнаран	Германы уран зохиол GERM 325, Герман хэлний уран зохиолын орчуулга GETR 328, Үйлдвэрлэлийн дадлага INT 400, Бакалаврын судалгааны ажил THES 400
3	Ч.Сэлэнгэмөрөн	Герман хэлний хэл зүй /анхан шат GERM 300, дунд шат 1 GERM 303, дунд шат 2 GERM 306/, Герман хэлний бизнесийн орчуулга GETR 330, Герман хэлний хэлмэрчлэхүй GERM 329, Герман хэлний албан бичгийн орчуулга GETR 327, Үйлдвэрлэлийн дадлага INT 400
4	Г.Гэрэлмаа	Герман хэлний ярих сонсох /анхан шат GERM 302, дунд шат 1 GERM 305, дунд шат 2 GERM 308, дээд шат GERM 311/, Үйлдвэрлэлийн дадлага INT 400, Бакалаврын судалгааны ажил THES 400
5	М.Одонтуяа	Герман хэлний авиа зүй GERM 320, Герман хэлний найруулга зүй GERM 324, Герман хэлний түүх GERM 334, Герман хэлний унших бичих /дээд шат GERM 310, Үйлдвэрлэлийн дадлага INT 400, Бакалаврын судалгааны ажил THES 400
6	Б.Энхболд	Герман хэлний унших бичих /анхан шат GERM 301, дунд шат 1 GERM 304, дунд шат 2 GERM 307/, Германы түүх GERM 333, Герман орон судлал GERM 332, Герман хэлний хэвлэл мэдээллийн хэл GERM 331, Үйлдвэрлэлийн дадлага INT 400, Бакалаврын судалгааны ажил THES 400

II. Оюутны нэрс

№	Овог нэр	Курс	Сонгосон байдал	Утасны дугаар
1	О.Одончимэг	4	Ангийн дарга	88771696 80719939
2	Б.Болорзул	4	Хос хөтөлбөрөөр сурдаг Хууль, орчуулга /Герман/	95330299
3	С.Энхмаа	4	МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг ШУС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг авсан	95358937
4	Ц. Булгансор	4	“Экологи-Эрдэм” клубын идэвхтэй гишүүн	94719793
5	Г. Тэмүүлэн	4	Дундаж оюутан Спортоор хичээллэдэг	88330581
6	Г.Солонго	4	МУИС-ийн тэтгэлэг авсан	99779562
7	Ж.Эгшиглэн	4	Илтгэх ирээдүй ТББ	99706251
8	У. Бодьмаа	3	Тэргүүний оюутан YFU байгууллагын сайн дурын гишүүн	96222192
9	Б. Ану	3	“Talented Student” идэвхтэй клубийн гишүүн	85458869
10	Х. Буянхишиг	3	Оюутны байранд амьдардаг	99445922
11	О. Намуундарь	3	Цагийн ажил “Дайберг Керн” худалдааны зөвлөх (цагийн ажил)	85856126
12	Э. Анхилуун	3	Хагас өнчин	88562502
13	М. Намуунаа	3	Гар бөмбөг тоглодог	89670009
14	Д. Пүрэвдаш	2	Орон нутгаас ирсэн	93133223
15	Ж. Оюундарь	2	Оюутны байранд амьдардаг	89565263
16	А.Эрхэмбилэг	2	Сагсан бөмбөгийн шигшээ багт тоглодог.	91518558
17	М.Марал-Эрдэнэ	2	Орон нутгаас ирсэн	89982582
18	Б.Хувьтөгөлдөр	2	Илтгэх урлаг академийн гишүүн	94510648

III. Ажил олгогчдын нэрс

№	Холбоо барих хүний нэр, албан тушаал	Байгууллагын нэр, ү/а-ны чиглэл	Цахим шуудангийн хаяг	Утас
1.	Энхманлай /Захирал/	ЭЙ БИ СИ Ворлд ХХК Сургалтын төв, орчуулгын товчоо	enkhmanlai@abcworld.mn	80834090, 99079045
2.	Ё.Отгонтөгс /Сургалтын албаны дарга/	Goethe Institut Mongolei	Otgontugs.Yondonjams@goethe.de	99168581
3.	Д.Отгонбаатар /Хэлтсийн дарга/	Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын менежмент, маркетингийн хэлтэс	otgonbaatar.sidia@gmail.com	99999533
4.	М.Мөнхнаран /Захирал/	МЭТОЦ ХХК Герман хэлний сургалтын төв	info@metots.mn	91914604
5.	Дарга Д.Дэлгэрбат	БГД-ийн Хүүхэд, залуучуудын ордон ОНӨТҮГ Дугуйлангийн сургалт, номын сан, тэмцээн уралдаан	hzs_ordon@yahoo.com	99101404
6.	Тамир /Захирал/	МЭТ Орчуулгын товчоо	metots.education@gmail.com	99994604
7.	Должинсүрэн /Захирал/	NATURSCHUTZ MONGOL LTD Culture Exchange - Volunteer Programs Travel to Mongolia – Tours around the World	info@naturschutz.mn info@naturschutz.mn	Tel: +976 7012 6906, Handy: +976 9907 6906 99076906, 80096906
8.	С.Очмандах /Захирал/	Зоог Апп Хуур мюзик фестиваль	ochmandakh@online.mn ochmandakh@gmail.com	99039902
9.	Н.Эрдэнэцэцэг /ГХЗАН-ийн дарга/	Дойче шуле	erdenetsetseg@germanschool.edu.mn	99182987
10	Б.Чинзориг /Ахлах ажилтан/	Customaware LLC	chinzo009@gmail.com	94193444

IV. Төгсөгчдийн нэрс

	Овог Нэр	Утасны дугаар	Ажиллаж буй байгууллага	Албан тушаал	Төгссөн он
1	Бямбадоржийн Батцэцэг	88469545	Орос - Монгол 3-р сургууль	Герман хэлний багш	2016
2	Алтангэрэлийн Маралмаа	95075256	Миг даатгал	Орчуулагч	2016

3	Амарбаясгалангийн Ануужин	85000456	SCC LLC	Маркетингийн менежер	2018
4	Рэнцэнбямбаагийн Даваадулам	89110666	Баянхайрхан Трейд ХХК	Маркетингийн менежер	2020
5	Энхтөрийн Алтанзул	95994488	БГД-ийн Хүүхэд, залуучуудын ордон ОНӨТҮГ	Герман хэлний багш	2018
6	Жавхлангийн Тэргэл	88555519	Монгол шуудан Чанарын удирдлагын хэлтэс	Мэргэжилтэн	2020
7	Дэлгэрмаагийн Цолмон	80009166	Эй Би Си Ворлд Институт	Герман хэлний багш	2020
8	Өлзийцэрэнгийн Халиун	95359872	Helrom GmbH	Гадаад харилцааны мэргэжилтэн	2020
9	Энхсүхийн Доржханд	99710779	МЕТ боловсролын төв	Герман хэлний багш	2019
10	Баярмөнхийн Ичинхорлоо	89122011	МЕТ боловсролын төв	Герман хэлний багш	2020
11	Төмөрбатын Саранцэцэг	99953205	Lendmn BBSB	Хэрэглэгчийн оператор	2018
12	Эрдэнэсайханы Дөлгөөн	99153944	ABC World Institute	Үйлчилгээний зөвлөх	2020
13	Алтансүхийн Ган- Эрдэнэ	86801980	Говь ХК	Маркетингийн менежер	2015
14	Золбоотын Алтанчимэг	95165696	Монгол дахь Гёте- Институт	Сургалтын албаны туслах	2017
15	Табигатын Жансая	99962612	Технозон ХХК	Техникийн оператор	2018
16	Болдбаатарын Билгүүнзаяа	89609522	Lendmn BBSB	Хэрэглэгчийн оператор	2018
17	Төмөрбаатарын Алтанзаяа	90173933	Deutsche Schule	Герман хэлний багш	2019
18	Баатарбилэгийн Ариунзаяа	99080205	Зоог апп ХХК	Маркетингийн менежер	2017
19	Төмөрхуягийн Соёлмаа	88529822	ABC World Institute	Герман хэлний багш, сургалтын менежер	2017
20	Батболдын Ганзориг	88104221	Ашид Капитал ББСБ ХХК	Маркетингийн менежер	2016
21	Алтангэрэлийн Дариймаа	94721998	МЕТ боловсролын төв	Герман хэлний багш	2021
22	Отгонзулын Гэрэлтуяа	99710769	МЕТ боловсролын төв	Герман хэлний багш	2021
23	Пүрэвдоржийн Анар	88999466	Micheal&amazonka	Загвар өмсөгч	2021
24	Батбаярын Анхилам	8989069	Zangia.mn	Маркетингийн менежер	2021
25	Баасанжавын Монголмаа	86119164	Юнител	Техникийн оператор	2021
26	Баярсайханы Хулан	80152486	ABC World Institute	Герман хэлний багш	2021
27	Нямдагвын Баярчимэг	88989328	ABC World Institute	Герман хэлний багш	2021

28	Ганхуягийн Жавзанпагма	80620828	-	ажилгүй	2021
29	Баярсайханы Энхжин	94721998	МЕТ сургалт, зуучлалын агентлаг	Орчуулагч	2021

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот-46а ш/х-330, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 47, Утас/Факс: (976-11) 32-54-35,
E-mail: sas@num.edu.mn, http://sas.num.edu.mn

2021.12.16 № *76/712*

танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛД

Тус сургуулийн Европ судлалын тэнхимийн Хэл шинжлэл (Герман) бакалаврын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн багийн тайлантай танилцлаа.

Сургууль болон хөтөлбөрийн зүгээс шинжээчдийн дүгнэлт, зөвлөмжийг зөвшөөрч, цаашид хөтөлбөрийн үйл ажиллагаандаа тусган ажиллах болно.

ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ
САЛБАР ХАРИУЦСАН
ДЭД ЗАХИРАЛ



П.ДЭЛГЭРЖАРГАЛ

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/